

ГАДААД МОНГОЛЫН АВТОНОМИ УНАСАН НЬ (Товчлол)

*ЛЮ СЮЕЯО**

Гадаад Монгол 1911 оны 11-р сард тусгаар тогтнолоо зарлаж, улмаар Манжийн Засгийн газраас хүрээнд сууж байсан Сандо амбаныг хөөж, (өргөсөн нэр Лю Цяо), Дундад иргэн улс байгуулагдсаны дараа түр ерөнхийлөгчөөс Гадаад Монголын Богд жавзундамба хутагтад нот илгээж, асуудлыг эргэцүүлэн бодож тусгаар тогтнолоо устгахыг хүссэн боловч жавзундамба энэ хүсэлтийг хүлээн авсангүй. Учир иймд Бээжин Оростой харилцаж, 1913 онд Хятад Оросын хооронд Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлаар хэлэлцэн зөвшөлдөж, эцэстээ 1913 оны 11-р сарын 5-нд Хятад, Орос хоёр тал “Хятад-Оросын мэдэгдэл” гарын үсэг зурав. Энэ мэдэгдэл нь нийт 5 зүйлтэй бөгөөд хамгийн гол санаа нь Хаант Орос нь гадаад Монгол дахь Хятад сюзеренитетийг хүлээн зөвшөөрөх, Хятад улс нь гадаад Монголын автономит эрхийг хүлээн зөвшөөрөхөд оршиж байв. Гадаад Монголын автономитын газар нутаг ба автономитын асуудлыг 1914 оны 9-р сараас эхлэн Хятад, Орос, Монгол гурван тал нийт 48 удаа хуралдаж, 1915 оны 6-р сарын 7-ны өдөр хэлэлцэн тогтож, 22 зүйл бүхий хэлэлцээр байгуулж. Гадаад Монголын автономиттой холбоотой асуудлыг нарийвчлан тогтсон байна.

1915 оны 6-р сарын 14-ний өдөр Бээжингийн умартын цэргийн засгийн газар Чэнь Лу-г гадаад Монголд суух анхны элчээр тусгай томилж, (Хятад, Орос, Монгол гурван талын хурлын Хятадын төлөөлөгч), Бээжингээс гадаад Монгол дахь сюзеренитетийг хэрэгжүүлэх, түүнээс дараах нь Чэнь И, Лю Чунхуй, Цян Шоуээн нарыг Улиастай, Ховд, Хиагтад суух туслах элчээр томилов. 1916 оны 8-р сараас 1919 он хүртэл хугацаанд Чэнь И-ийг тэргүүн элчээр томилсон байна. Энэ хоёр элч Монголд суух дөрвөн жилийн хугацаандаа хил хязгаарын асуудлыг явуулахдаа тэвчээртэй аядуу байхыг ойлгож, улмаар гадаад Монголын ноёд, лам нартай ойртон нийлж, гадаад Монголын дээд хүрээнийхний итгэлийг хүлээх болов. Энэ үед (1919) Орос улсын дотоод байдал тогтворгүйдэж улаан намын хувьсгал болон нармай Монголын хөдөлгөөн гэгчээс гадаад Монгол нь эмээх болов. Энэ үед Чэнь И энэ боломжийг даруй ашиглан автономоо устгах санал дэвшүүлж төвийн хамгаалалтанд орох нь хамгийн дөхөм арга гэж үзсэнийг нь гадаад Монголын дээд хүрээнийхэн хүлээн авч хоёр

* Лю Сюеяо - Тайваний Соёлын их сургуулийн улс төрийн хүрээлэнгийн дэд профессор

тал автономоо устгасны дараах зарим асуудлыг дараа хэлэлцэхээр болов. Чэнь И хангалттай тэвчээр гаргаж, хоёр тал эвийн байдалд автономоо устгах хэлэлцээр байгуулах нь гадаад Монголын асуудлыг амжилттай дуусгах сайн арга гэж үзэж байв. Гэтэл энэ үед санаанд ороогүй явдал болж, Бээжингийн эрх баригчид Сюй Шужаныг баруун хойт хязгаарын элчээр томилж, цэрэг удирдуулан гадаад Монголд оруулав. Сюй Шужан нь хязгаарын үндэстний асуудлыг хэрхэн шийдэх талаар огт мэдлэггүй бөгөөд тэдний ёс заншлыг үл хүндэтгэн, гавьяа байгуулахаар яарч Чэнь И ба гадаад Монголын эрх баригчдын хооронд боловсруулсан “гадаад Монголын тохинуулах дүрэм” гэгчийг огт ашиггүй зүйл хэмээн үзэж Чэнь И-ийг үг хэлэхийг хориглон харин Чэнь И энэ үеийг ашиглах нь зүйтэй хэмээн үзэж, цэргийн хүчээр Богд Жавзундамба хутагтын ордны болон гол ноёдын орд өргөөг бүслэв. Цэргийн сүр хүчээс айсан гадаад Монголын эрх баригчид автономоо устгах албан бичигт аргагүйн эрхэнд гарын үсэг зурж, 1919 оны 11-р сарын 22-нд албан ёсоор гардуулав. Гадаад Монголын автономит эрх олсон ба устгахад ердөө 4 жил 5 сар 6 хоног орсон байна. (Чэн Лу анхны элчээр томилогдсон 1915.6.16-наас автономит эрхээ устгасан 1919.11.22)

Сюй Шужан цэргийн сүр хүч үзүүлэх аргаар гадаад Монголын автономит эрхийг устгах явцыг түрэгчилсэн боловч гадаад Монголын ард түмнийг өргөмжлөн хүндэтгэх сэтгэлийг шархлуулан, Монгол, Хятадын үндэстний эв эед хар сүүдэр авчирсан юм. Гадны хүч орох л юм бол гадаад Монголын ард түмэн Бээжинд сүжиг алдах болсныг эргэн харах болжээ.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав